



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: САГ-2021/26/СТА-ТЭЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:Naranchimegts@audit.gov.mn">Naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: <a href="mailto:Sambuunyamy@audit.gov.mn">Sambuunyamy@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:Enkhdalaid@audit.gov.mn">Enkhdalaid@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Эрдэнээул Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:Erdenezulb@audit.gov.mn">Erdenezulb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал ...	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	14
3.5.2 Авлага .....	15
3.5.3 Урьдчилгаа .....	16
3.5.4 Бараа материал .....	16
3.5.5 Үндсэн хөрөнгө .....	17
3.5.6 Өр төлбөр .....	18
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо .....	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	21
3.8 Аудитын гол асуудал .....	21
3.9 Шилэн дансны мэдээлэл .....	22
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	22
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
4. Аудитын илрүүлэлт .....	23
Албан шаардлага .....	23
Зөвлөмж .....	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	26
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт .....	32

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ГИШҮҮН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД  
З.МЭНДСАЙХАН ТАНАА

2021.04.26 № 1325  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 242,855.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, тодорхойгүй, найдваргүй авлага, өглөг үүссэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалтын горим зөрчигдсөн, эзэмшлийг шилжүүлэн аваагүй, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг алдаа, зөрчлүүд нь УСНББОУС болон Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журам, зааварт нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг", "Оршин байх", "Иж бүрэн байх", "Толилуулга ба Тодруулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	640,787,046.4	706,012,987.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,418,938.0	77,478,852.7
АВЛАГА	519,389,632.8	544,751,122.2
УРЬДЧИЛГАА	2,143,386.4	4,933,685.0
БАРАА МАТЕРИАЛ	37,938,162.3	28,211,436.2
НӨӨЦИЙН БАРАА	74,896,926.8	50,637,891.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	174,393,114.3	197,739,024.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	174,393,114.3	197,739,024.4
Биет хөрөнгө	141,166,789.3	151,951,268.5
Биет бус хөрөнгө	33,226,325.0	45,787,755.8
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>815,180,160.7</b>	<b>903,752,011.9</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	329,966,631.6	416,001,054.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	105,730,485.7	104,723,973.2
Богино хугацаат зээлийн өглөг	13,753,172.1	12,469,335.6
Өглөг	91,516,145.6	91,555,700.3
Урьдчилж орсон орлого	461,168.0	698,937.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	224,236,145.8	311,277,080.9
Урт хугацаат үнэт цаас	50,047,797.3	43,646,666.3
Урт хугацаат зээл	174,188,348.5	267,630,414.6
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	485,213,529.1	487,750,957.8
Засгийн газрын хувь оролцоо	485,213,529.1	487,750,957.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	127,824,157.6	133,410,755.6
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,473,118.2	15,763,789.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32,010.0	5,973,218.8
Хуримтлагдсан үр дүн	310,035,199.1	293,714,893.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,849,044.2	38,888,300.9
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>815,180,160.7</b>	<b>903,752,011.9</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>252,255,513.3</b>	<b>394,669,828.7</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,611,118.4	67,205,575.8
Нийтлэг татварын бус орлого	58,611,118.4	67,205,575.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	193,644,394.9	327,464,252.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>154,909,936.7</b>	<b>364,538,772.0</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	154,909,936.7	364,538,772.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,171,787.1	110,482,189.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,880,279.8	16,643,923.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,667,890.0	2,181,861.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,463,652.4	1,694,359.6
Хангамж, бараа материалын зардал	2,270,391.9	3,670,027.4
Нормативт зардал	18,910,027.0	22,939,076.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,157,485.3	669,560.1
Томилолт, зочны зардал	808,232.5	631,035.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,977,091.7	41,817,572.8
Бараа үйлчилгээний бусад зардал	21,036,736.4	20,234,772.3
ХҮҮ	-	10,081,291.4
ТАТААС	49,655,766.9	63,481,290.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,082,382.7	180,494,001.2
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>97,345,576.6</b>	<b>30,131,056.7</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	949,692.5	338,717.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	36,410,130.0	30,805,987.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>61,885,139.2</b>	<b>(336,213.1)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>431,319,637.2</b>	<b>431,319,637.2</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(7,712,612.8)	(7,712,612.8)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,607,024.3	423,607,024.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(78,750.9)	(78,750.9)
Зарласан ногдол ашиг	(199,883.4)	(199,883.4)
Тайлант үеийн үр дүн	61,885,139.2	61,885,139.2
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>485,213,529.1</b>	<b>485,213,529.1</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,032,530.4	9,032,530.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,246,059.6	494,246,059.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,052,015.4)	(9,052,015.4)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	175,000.0	175,000.0
Өмчид гарсан өөрчлөлт	3,261,400.9	3,261,400.9
Зарласан ногдол ашиг	(543,273.2)	(543,273.2)
Тайлант үеийн үр дүн	(336,213.1)	(336,213.1)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>487,750,957.8</b>	<b>487,750,957.8</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>439,469,933.9</b>	<b>790,938,769.2</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	297,016,800.6	469,513,089.8
Нийтлэг татварын бус орлого	297,016,800.6	469,513,089.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,453,133.2	321,425,679.4
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>374,662,882.1</b>	<b>687,495,478.2</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	374,662,882.1	687,495,478.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,087,206.4	432,252,988.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,405,900.9	17,786,219.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,972,993.9	2,424,244.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,910,212.3	2,817,811.0
Хангамж, бараа материалын зардал	3,313,256.6	4,315,048.9
Нормативт зардал	13,496,833.4	13,997,250.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,506,025.6	1,581,592.3
Томилолт, зочны зардал	789,026.4	642,392.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	233,044,455.8	380,471,173.6
Бараа үйлчилгээний бусад зардал	7,648,501.4	8,217,256.3
ХҮҮ	-	4,135,837.6
ТАТААС	72,689,616.5	66,427,405.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,886,059.3	184,679,245.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>64,807,051.7</b>	<b>103,443,291.1</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>184,346.8</b>	<b>7,289,452.5</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>24,668,200.0</b>	<b>22,590,682.2</b>
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,668,200.0	22,590,682.2
Дотоод эх үүсвэрээр	24,668,200.0	22,590,682.2
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(24,483,853.2)</b>	<b>(15,301,229.6)</b>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(48,818,492.0)	(17,082,146.8)
Бусад эх үүсвэр	23.9	11,833,729.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	10,088,540.1	21,971,283.2
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	38,549,986.8	6,201,712.3
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	179,989.0	742,881.1
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(8,495,293.4)</b>	<b>71,059,914.7</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,914,231.4	6,418,938.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,418,938.0	77,478,852.7



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>362,942,162,000.00</b>	<b>347,881,167,780.61</b>	<b>15,060,994,219.39</b>	<b>95.85</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>326,386,036,400.00</b>	<b>307,824,400,922.91</b>	<b>18,561,635,477.09</b>	<b>94.31</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>73,865,724,900.00</b>	<b>67,765,080,409.42</b>	<b>6,100,644,490.58</b>	<b>91.74</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,433,431,600.00</b>	<b>13,302,864,398.65</b>	<b>130,567,201.35</b>	<b>99.03</b>
Үндсэн цалин	9,432,092,000.00	9,360,484,969.00	71,607,031.00	99.24
Нэмэгдэл	3,292,041,200.00	3,217,409,892.80	74,631,307.20	97.73
Унаа хоолны хөнгөлөлт	667,601,400.00	694,406,227.39	(26,804,827.39)	104.02
Урамшуулал	41,697,000.00	30,563,309.46	11,133,690.54	73.30
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,805,862,700.00</b>	<b>1,756,412,286.54</b>	<b>49,450,413.46</b>	<b>97.26</b>
Тэтгэврийн даатгал	1,276,305,100.00	1,235,106,841.30	41,198,258.70	96.77
Тэтгэмжийн даатгал	132,447,400.00	129,910,913.54	2,536,486.46	98.08
ҮОМШӨ-ний даатгал	105,957,200.00	106,168,430.23	(211,230.23)	100.20
Ажилгүйдлийн даатгал	26,490,100.00	26,161,132.03	328,967.97	98.76
Эрүүл мэндийн даатгал	264,662,900.00	259,064,969.44	5,597,930.56	97.88
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,684,787,300.00</b>	<b>1,587,272,463.84</b>	<b>97,514,836.16</b>	<b>94.21</b>
Гэрэл, цахилгаан	577,604,500.00	545,522,216.91	32,082,283.09	94.45
Түлш, халаалт	898,844,600.00	862,091,921.75	36,752,678.25	95.91
Цэвэр, бохир ус	121,347,300.00	99,174,646.18	22,172,653.82	81.73
Байрны түрээс	86,990,900.00	80,483,679.00	6,507,221.00	92.52
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,391,104,500.00</b>	<b>1,289,119,007.53</b>	<b>101,985,492.47</b>	<b>92.67</b>
Бичиг хэрэг	297,216,100.00	271,116,406.00	26,099,694.00	91.22
Тээвэр, шатахуун	660,916,000.00	623,528,602.00	37,387,398.00	94.34
Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	288,724,100.00	269,841,867.53	18,882,232.47	93.46
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,333,100.00	7,052,000.00	3,281,100.00	68.25
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133,915,200.00	117,580,132.00	16,335,068.00	87.80
<b>Нормативт зардал</b>	<b>12,198,992,500.00</b>	<b>12,193,615,068.38</b>	<b>5,377,431.62</b>	<b>99.96</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,112,316,100.00	12,108,801,334.38	3,514,765.62	99.97
Нормын хувцас, зөөлөн эдлэл	86,676,400.00	84,813,734.00	1,862,666.00	97.85
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,993,681,600.00</b>	<b>1,671,373,510.50</b>	<b>322,308,089.50</b>	<b>83.83</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,049,986,000.00	913,931,354.00	136,054,646.00	87.04
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	146,661,300.00	144,158,398.00	2,502,902.00	98.29
Урсгал засвар	797,034,300.00	613,283,758.50	183,750,541.50	76.95
<b>Томилот, зочны зардал</b>	<b>553,825,800.00</b>	<b>433,602,093.00</b>	<b>120,223,707.00</b>	<b>78.29</b>
Дотоод албан томилот	529,633,300.00	409,409,593.00	120,223,707.00	77.30
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,630,665,500.00</b>	<b>34,934,121,813.58</b>	<b>4,696,543,686.42</b>	<b>88.15</b>

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,795,831,200.00	34,237,508,502.90	4,558,322,697.10	88.25
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	28,269,600.00	26,749,800.00	1,519,800.00	94.62
Даатгалын үйлчилгээ	73,890,200.00	66,066,445.00	7,823,755.00	89.41
Тээврийн хэрэгслийн татвар	27,846,800.00	18,888,833.90	8,957,966.10	67.83
Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,554,400.00	5,626,560.00	1,927,840.00	74.48
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	617,307,800.00	514,757,670.78	102,550,129.22	83.39
Газрын төлбөр	79,845,500.00	64,524,001.00	15,321,499.00	80.81
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	-	120,000.00	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,173,373,400.00</b>	<b>596,699,767.40</b>	<b>576,673,632.60</b>	<b>50.85</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,158,611,600.00	584,119,767.40	574,491,832.60	50.42
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,761,800.00	12,580,000.00	2,181,800.00	85.22
<b>ТАТААС</b>	<b>73,498,720,900.00</b>	<b>62,560,221,899.43</b>	<b>10,938,499,000.57</b>	<b>85.12</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>11,000,000,000.00</b>	<b>1,183,047,908.82</b>	<b>9,816,952,091.18</b>	<b>10.75</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	11,000,000,000.00	1,183,047,908.82	9,816,952,091.18	10.75
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>62,498,720,900.00</b>	<b>61,377,173,990.61</b>	<b>1,121,546,909.39</b>	<b>98.21</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,498,720,900.00	61,377,173,990.61	1,121,546,909.39	98.21
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>179,021,590,600.00</b>	<b>177,499,098,614.06</b>	<b>1,522,491,985.94</b>	<b>99.15</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>709,530,500.00</b>	<b>707,165,029.08</b>	<b>2,365,470.92</b>	<b>99.67</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	709,530,500.00	707,165,029.08	2,365,470.92	99.67
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>178,312,060,100.00</b>	<b>176,791,933,584.98</b>	<b>1,520,126,515.02</b>	<b>99.15</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	206,333,400.00	180,448,036.17	25,885,363.83	87.45
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	176,782,989,800.00	175,352,642,948.00	1,430,346,852.00	99.19
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,002,731,900.00	955,273,565.81	47,458,334.19	95.27
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	320,005,000.00	303,569,035.00	16,435,965.00	94.86
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,770,650,000.00</b>	<b>20,585,483,696.61</b>	<b>13,185,166,303.39</b>	<b>60.96</b>
Барилга байгууламж	18,905,650,000.00	6,118,265,588.00	12,787,384,412.00	32.36
Их засвар	1,300,000,000.00	1,103,071,114.00	196,928,886.00	84.85
Тоног төхөөрөмж	1,215,000,000.00	1,036,822,652.00	178,177,348.00	85.34
Стратегийн нөөц хөрөнгө	12,350,000,000.00	12,327,324,342.61	22,675,657.39	99.82
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>2,785,475,600.00</b>	<b>19,471,283,161.09</b>	<b>(16,685,807,561.09)</b>	<b>699.03</b>
Эргэж төлөгдөх зээл	2,785,475,600.00	19,471,283,161.09	(16,685,807,561.09)	699.03

<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>362,942,162,000.00</b>	<b>350,176,292,660.01</b>	<b>12,765,869,339.99</b>	<b>96.48</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>346,220,150,300.00</b>	<b>315,285,420,480.20</b>	<b>30,934,729,819.80</b>	<b>91.07</b>
Улсын төсвөөс санхүүжих	346,220,150,300.00	315,285,420,480.20	30,934,729,819.80	91.07
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>85,775,536,100.00</b>	<b>45,459,721,949.72</b>	<b>40,315,814,150.28</b>	<b>53.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,055,963,800.00	44,171,450,637.33	33,884,513,162.67	56.59
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,719,572,300.00	1,288,271,312.39	6,431,300,987.61	16.69
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(69,053,524,400.00)</b>	<b>(10,568,849,769.91)</b>	<b>(58,484,674,630.09)</b>	<b>15.31</b>
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(69,053,524,400.00)	(10,568,849,769.91)	(58,484,674,630.09)	15.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,022,164.86	(25,022,164.86)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	86,178,777.31	(86,178,777.31)	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Дүн
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,041,172,025.54</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,084,226,181.54</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>22,774,651,986.81</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>133,210,430.63</b>
Үндсэн цалин	6,715,000.00
Урамшуулал	2,565,000.00
Гэрээт ажлын хөлс	123,930,430.63
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>624,408.00</b>
Тэтгэврийн даатгал	624,408.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,986,224.50</b>
Гэрэл, цахилгаан	13,986,224.50
Түлш, халаалт	4,000,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>263,584,630.57</b>
Бичиг хэрэг	22,096,254.00
Тээвэр, шатахуун	213,406,035.57
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,290.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,997,051.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,806,105,197.10</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,769,965,197.10
Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,140,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>847,776,889.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	652,754,039.00
Тавилга	39,483,202.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	44,611,300.00
Урсгал засвар	110,928,348.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>204,038,910.00</b>
Дотоод албан томилолт	204,038,910.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,004,653,673.01</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,004,644,143.01
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,530.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,496,671,624.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	6,492,843,624.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,828,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,309,574,194.73</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>156,333,852.65</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,190,093.91
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	87,143,758.74
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,153,240,342.08</b>
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	174,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,153,066,342.08
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,956,945,844.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,956,945,844.00</b>
Тоног төхөөрөмж	2,927,196,800.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,749,044.00

<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>26,917,143,664.36</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>26,917,143,664.36</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,529,708,925.41
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,340,651,373.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,458,660,228.83
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,588,123,137.12
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(124,028,361.18)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	408,577,032.71
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	284,548,671.53

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлагнал, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1096 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд дараах хяналт шалгалтуудыг хийж, үр дүнг үнэлсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг дарга нартай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 онд байгуулсан гэрээний дагуу аймгуудын Санхүүгийн хяналт, аудитын албанаас 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт дотоод аудит хийсэн байна. Хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг үндэслэн илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн, эрсдэлийн үнэлгээ гаргасан;

- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /нэмэлт санхүүжилт/ төслийн 2018-2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулахаар 37 зөвлөмж өгсөн;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 69 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлын хүрээнд 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 903,752.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9,037.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,418.9 сая, эцсийн үлдэгдэл 77,478.8 сая төгрөг болж, 71,059.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	28.8	6.1	(22.7)	0.01
Банканд байгаа бэлэн мөнгө	6,390.1	9,276.5	2,886.4	12.0
Хадгаламж	-	68,196.2	68,196.2	88.0
<b>Дүн</b>	<b>6,418.9</b>	<b>77,478.8</b>	<b>71,059.9</b>	<b>100</b>

*Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн нь Сангийн яаманд харьяалалтай байсан Зээлийн батлан даалтын сан шилжин ирснээр 61,089.6 сая төгрөгийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Банкан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогын 8,728.4 сая, хөрөнгө оруулалтын барьцаа

дэнчингийн 282.0 сая, техник хяналтын 234.0 сая, 5 төсөвт байгууллагын ахмадын сангийн 32.1 сая төгрөгийн үлдэгдэл тус тус байршиж байна.

Хадгаламжийн дансны үлдэгдэлд Зээлийн батлан даалтын сангийн арилжааны 7 банкинд зээлийн батлан даалт гаргасан харилцагч бүрээр байршуулсан 68,196.2 сая төгрөг тайлагнагдсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Ховд аймгийн ХХААГ 52.1 сая, ХХААХҮЯ 47.1 сая төгрөг/.

**3.5.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 519,389.6 сая, эцсийн үлдэгдэл 544,751.1 сая төгрөг болж, 25,361.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	55.4	54.4	-1.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	121,898.2	29,192.5	-92,705.7
Татаас, санхүүжилтийн авлага	5,778.2	3,587.0	-2,191.2
Дансны авлага /ТӨҮГ/	1,347.1	1,530.0	182.9
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	24.6	42.2	17.5
Байгууллагаас авах авлага	24,971.1	26,072.2	1,101.1
Хувь хүмүүсээс авах авлага	470.9	343.2	-127.7
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	364,844.0	483,929.5	119,085.6
<b>Дүн</b>	<b>519,389.6</b>	<b>544,751.1</b>	<b>25,361.5</b>

*Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэл нэмэгдэхэд Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтад гаргаагүй зээлийн санхүүжилт, үүрэг гүйцэтгэлийн нийт 31,359.5 сая төгрөгийн авлага шилжин ирсэн нь голлон нөлөөлсөн.

Авлагын үлдэгдэлд төлөгдөх хугацаа хэтэрсэн, олон жилийн насжилттай 259,840.3 сая төгрөгийн дараах үлдэгдлийг тодруулж, тайлагнасан байна. Тухайлбал:

- Хөдөө аж ахуйг дэмжих сангаас олгосон тусламж дэмжлэгийн зээл, зээлийн хүүгийн 213,500.5 сая төгрөг;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд ХХААХҮЯ, Сангийн яам, Капитал банкны хооронд 2011, 2016 онд байгуулсан дамжуулан зээлдүүлэх хамтран хэрэгжүүлэх гэрээний хүрээнд Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 42,901.3 сая төгрөг;
- Малын удмын санд Мал хамгаалах сангаас шилжин ирсэн 2009-2019 онуудад үүссэн 2,450.0 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын санд 2016-2019 онд үүссэн 988.5 сая төгрөгийн авлага байна.

Дээрх олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн найдваргүй авлага үүссэн нь төсвийн хөрөнгө үрэгдэх, дамжуулан зээлийн өр төлбөрөө барагдуулах төлбөрийн чадваргүй болж, алдагдал хүлээх зэрэг эрсдэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй /ЖДҮХС 156,314.6 сая, ХААДС 185,901.8 сая, Биокомбинат УТҮГ 117.8 сая төгрөг/.



- Харилцагч болон үүссэн шалтгаан нөхцөл тодорхойгүй авлага бүртгэсэн /ХААДС 1,367.3 сая, Биокомбинат УТҮГ 6.0 сая төгрөг /,
- Олон жил болсон, төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй /Ховд аймгийн ХХААГ 553.1 сая, Хөвсгөл аймгийн ХХААГ 18.7 сая төгрөг/,
- Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн /Булган аймгийн ХХААГ 5.9 сая, Дархан-Уул аймгийн ХХААГ 3.4 сая төгрөг/.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,143.4 сая, эцсийн үлдэгдэл 4,933.7 сая төгрөг болж, 2,790.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,143.4	4,933.7	2,790.3
<b>Дүн</b>	<b>2,143.4</b>	<b>4,933.7</b>	<b>2,790.3</b>

Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2019 оноос эхлэн 8 байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж буй бараа ажил, үйлчилгээний урьдчилан төлсөн төлбөрүүд байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материал, нөөцийн барааны эхний үлдэгдэл 112,835.1 сая, эцсийн үлдэгдэл 78,849.3 сая төгрөг болж, 33,985.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материал, нөөцийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалт, эм боох материал	16,766.5	12,404.1	(4,362.4)
Бэлэн бүтээгдэхүүн	8,528.2	4,780.8	(3,747.4)
Хангамжийн материал	9,213.9	7,639.7	(1,574.2)
Мал амьтад	3,429.5	3,386.8	(42.7)
<b>Дүн</b>	<b>37,938.2</b>	<b>28,211.4</b>	<b>(9,726.7)</b>
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>74,896.9</b>	<b>50,637.9</b>	<b>(24,259.0)</b>
<b>Дүн</b>	<b>74,896.9</b>	<b>50,637.9</b>	<b>(24,259.0)</b>
<b>Нийт дүн</b>	<b>112,835.1</b>	<b>78,849.3</b>	<b>(33,985.7)</b>

Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онд бэлтгэсэн 5,172.1 сая төгрөгийн тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах хашааг ашиглалтад оруулж 5 аймагт шилжүүлсэн нь бараа материалын үлдэгдэл буурахад голлон нөлөөлсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах хашааг Дорнод, Хэнтий, Төв аймгуудад шилжүүлэх шийдвэр гарсан ч ковид цар тахлын онцгой нөхцөл байдлаас шалтгаалан хүлээлгэн өгөөгүй 2,538.9 сая төгрөгийн, мөн харьяа байгууллагуудад шилжүүлэх шийдвэр нь гарсан 476.7 сая төгрөгийн хөрөнгө ХХААХҮЯ-ны Хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн тайланд тусгай зориулалттай материалын дансанд бүртгэлтэй байна.

Нөөцийн бараа материалын үлдэгдэл 24,259.0 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолоор “Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах санаачилгыг дэмжих зорилгоор Хөдөө аж ахуйг дэмжих сангийн өр, авлагыг ангилж тэдгээрээс чанаргүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан авлагыг хуулийн хүрээнд үе шаттай чөлөөлөх, үлдэгдэл бараа материал, зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжийн үнийг 50 хүртэл хувиар хөнгөлөх замаар ашиглалтыг сайжруулах, ажлын байрыг хадгалах арга хэмжээ авах”-ыг зөвшөөрсний дагуу Хөдөө аж ахуйг дэмжих

сангийн нөөцийн бараанд бүртгэлтэй дэмжлэгийн техник хэрэгсэлд 50 хувиар хөнгөлөлт тооцож, борлуулсантай холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй /Ховд аймгийн ХХААГ 180.1 сая, ЖДҮХС 125.7 сая, ХХААХҮЯ 42.5 сая, Говь-Алтай аймгийн ХХААГ 30.5 сая, Малын удмын сангийн үндэсний төв 22.4 сая төгрөг/
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бараа материалын үлдэгдлийг төсөвт байгууллагуудад мөрдөгдөх дансны ангиллаар бүртгэсэн, мөн зарим бараа материалыг дансны ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.

**3.5.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 227,608.2 сая, эцсийн үлдэгдэл 259,385.1 сая төгрөг болж, 31,776.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	109,701.1	123,335.3	13,634.1
Авто-тээврийн хэрэгсэл	14,571.8	17,269.7	2,697.9
Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,341.8	38,954.6	1,612.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,601.6	5,262.8	661.2
Зам, гүүрийн байгууламж	3,534.0	3,542.8	8.8
Бусад үндсэн хөрөнгө	12,198.7	13,254.7	1,056.0
Дуусаагүй барилга, байгууламж	11,158.8	10,435.3	(723.5)
Програм хангамж	1,819.3	2,225.3	406.0
Бусад биет бус хөрөнгө	32,681.1	45,104.6	12,423.5
<b>Дүн</b>	<b>227,608.2</b>	<b>259,385.1</b>	<b>31,776.9</b>

*Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн өсөлтөд дараах хөрөнгүүд нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Засгийн газрын 93 дугаар тогтоолоор “Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” УТҮГ болон Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шилжин ирсэн “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-уудыг нэгтгэн “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв” УТҮГ үүсгэн байгуулагдаж, 8,330.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн;
- Сангийн яамнаас Зээлийн батлан даалтын сан шилжин ирж 2,694.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн;
- ТӨБЗГ-ын 2020 оны А-1/960 дугаар албан бичиг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/144 дүгээр тушаалын дагуу Татварын ерөнхий газарт шилжүүлсэн Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах Рашаант дахь “Нефьт болон хий боловсруулах үйлдвэр”-ийн төслийн 11,818.8 сая төгрөгийн 69 га газрыг орлого авсан.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,663.6 сая, балансаас балансад 20,167.8 сая, үнэ төлбөргүй, хандиваар 6,187.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 7,897.8 сая төгрөгийн хөрөнгийг баланс хооронд шилжүүлж, 1,732.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Дуусаагүй барилга, байгууламжийн дансанд 10,435.3 сая төгрөгийн дүн бүхий дараах хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Гэрээний хэрэгжилтийн хугацаанд байгаа 3,670.0 сая төгрөгийн Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж, 816.2 сая төгрөгийн Мал эмнэлгийн сорил

баталгаажуулалтын улсын төв лабораторийн барилга, 100.0 сая төгрөгийн Жижиг дунд үйлдвэрийн газрын барилга;

- Шүүхийн шийдвэрээр Алтан дорнод монгол ХХК-ийн татварын өрөнд хураалгасан 3,485.6 сая төгрөгийн сургалтын зориулалттай барилга;
- Дархан уул аймгийн Хонгор суманд 2018 онд барьсан Малын удмын сангийн үндэсний төв цогцолборын 24 айлын орон сууц, төлийн байр, музейн байрны 30.2 сая төгрөгийн шугам хоолой /барилгын төсөв батлагдаагүй/;
- Хэнтий аймгийн ХХААГ-ын конторын барилгын суурийг 2014 онд Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн санхүүжилтээр барьсан ч Конторын барилгын төсөв батлагдаагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хангалтгүй, зохих арга хэмжээг аваагүй /Зээлийн батлан даалтын сан 21.7 сая, Хэнтий аймгийн ХХААГ 237.0 сая, ХХААХҮЯ-д ашиглаж буй 3, Мал эмнэлгийн ерөнхий газарт ашиглаж буй 2 автомашины эзэмших эрхийг шилжүүлэн аваагүй, Сүхбаатар аймгийн ХХААГ бусад байгууллагад автомашинаа ашиглуулсан/;
- Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын 24 тоот шийдвэрийн дагуу Чингис хаан банкны авлагыг барагдуулахаар 2,174.1 сая төгрөгийн 476.7 м2 талбай бүхий оффис худалдан авах гэрээ хийж, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээгүй, хөрөнгийг бүртгэсэн;
- ХААДС-ийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,125.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэл бодитой оршин байхгүй, элэгдлийг хуримтлуулан бүртгэсэн;

**3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 329,966.6 сая, эцсийн үлдэгдэл 416,001.1 сая төгрөг болж, 86,034.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	105,730.5	104,724.0	-1,006.5	25.2
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	13,184.0	11,900.2	-1,283.8	2.9
Төслийн зээл	569.1	569.1	0.0	0.1
Зээлийн хүүгийн өглөг	384.1	5,945.5	5,561.3	1.4
Бараа үйлчилгээний өглөг	36.6	161.9	125.4	0.0
Бусад өглөг	91,095.4	85,448.3	-5,647.1	20.5
Урьдчилж орсон орлого	461.2	698.9	237.8	0.2
Урт хугацаат өр төлбөр дүн	224,236.1	311,277.1	87,040.9	74.8
Бонд	50,047.8	43,646.7	-6,401.1	10.5
Урт хугацаат зээл	174,188.3	267,630.4	93,442.1	64.3
<b>Нийт дүн</b>	<b>329,966.6</b>	<b>416,001.1</b>	<b>86,034.4</b>	<b>100</b>

*Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт өр төлбөрийн 74.8 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байгаа бөгөөд Хөдөө аж ахуйг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний дамжуулан зээлийн Сангийн яам, Хөгжлийн банк, Ди Би Эм лизинг ХХК-д буцаан төвлөрүүлэх өглөг, Зээлийн батлан даалтын сангийн зээлийн санхүүжилтийн урт хугацаат өглөг тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь Зээлийн батлан даалтын сан шилжин ирж, Сангийн яамнаас дамжуулан зээлийн хэлэлцээрийн дагуу олгосон зээлийн санхүүжилтийг буцаан төлөхөөр бүртгэсэн урт хугацаат өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,006.5 сая төгрөгөөр буурсан бөгөөд нийт өглөгийн 20.5 хувийг байгууллага, хувь хүмүүст төлөх бусад өглөг, 2.9 хувийг Мал хамгаалах сангаас улсын төсөвт төвлөрүүлэх өвс тэжээлийн хөнгөлөлтэй зээлийн өглөг, 1.4 хувийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүгийн өглөг тус тус эзэлж байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /ЖДҮХС 2,097.0 сая, ХААДС 221,981.7 сая, Зээлийн батлан даалтын сан 95,603.1 сая төгрөг/,
- Харилцагч болон үүссэн шалтгаан нөхцөл тодорхойгүй өглөг бүртгэсэн, харилцагчийн тооцоог данс зөрүүлэн хаасан /ХААДС 10,710.5 сая төгрөг /,
- ХААДС нийт 481.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын дансанд харилцагчийн болон ажил гүйлгээний утга тодорхойгүй, бөөн дүнгээр бүртгэсэн.

### **3.5.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 485,213.5 сая, эцсийн үлдэгдэл 487,751.0 сая төгрөг болж, 2,537.4 сая төгрөгөөр өссөн байна.

#### **Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	127,824.2	133,410.8	5,586.6	27.4
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,473.1	15,763.8	3,290.7	3.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32.0	5,973.2	5,941.2	1.2
Өмнөх үеийн үр дүн	248,150.1	294,051.1	45,901.0	60.3
Тайлант үеийн үр дүн	61,885.1	-336.2	-62,221.4	(0.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,849.0	38,888.3	4,039.3	8.0
<b>Дүн</b>	<b>485,213.5</b>	<b>487,751.0</b>	<b>2,537.4</b>	<b>100</b>

Эх сурвалж: ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 487,751.0 сая төгрөг болж 0.5 хувиар өссөн байна.

Зээлийн батлан даалтын сан шилжин ирснээр төрийн өмч 8,000.0 сая төгрөгөөр, эздийн өмчийн бусад хэсэг 5,793.2 сая төгрөгөөр, “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв” УТҮГ үүсгэн байгуулсантай холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 7,710.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгад өмнөх үеийн үр дүнг бууруулан тайлагнасан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв үүсгэн байгуулагдсан, Зээлийн батлан даалтын сан шилжин ирсэнтэй холбоотойгоор 14,640.8 сая төгрөгийн бодлогын өөрчлөлт орсон,
- Нягтлан бодох бүртгэлийн алдаа, буруу тооцооллын улмаас 5 байгууллага 38.4 сая төгрөгийн залруулга хийж, бодлогын өөрчлөлтөд тайлагнасан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Төсвийн төлөвлөлт**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын харьяа байгууллагуудад 547,055.4 сая төгрөгийг зарцуулахаар төсвийн төслөө боловсруулж, хүргүүлсэн бөгөөд 186,898.7 сая төгрөгөөр бууруулж, 360,156.7 сая төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 362,942.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 326,386.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 30,770.6 сая төгрөг батлагджээ. Мөн төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх эх үүсвэр, эргэн төлөлтөд нийт 69,053.5 сая төгрөгийг бүрдүүлж, шилжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт зардлын 346,220.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 85,775.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 312,113.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 34,106.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Төсөвт байгууллагууд үйл ажиллагааны орлогоос 45,218.3 сая төгрөгийг бүрдүүлсэн боловч орлогын төлөвлөгөө 40,557.3 сая төгрөгөөр тасарсан нь коронавируст цар тахлын үед жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн тогтвортой байдлыг хангах, ажлын байрыг хадгалах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/84, А/373 дугаар тушаалын дагуу зээлийн үндсэн төлөлт, алданги тооцооллыг 6 сарын хугацаагаар зогсоосноос голлон шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 347,881.2 сая төгрөг буюу 95.9 хувьтай бөгөөд 15,061.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,696.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг дунд үйлдвэрийн газар, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрх нээгдээгүй тул зарцуулагдаагүй, дараа онд шилжүүлэхээр өглөг үүсгэсэн;
- Төрийн өмчит байгууллагад олгох татаас санхүүжилтийн 10,938.5 сая төгрөгийн үлдэгдэл нь Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолын дагуу газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгохоор төлөвлөсөн 6,000.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлтөөс 4,800.0 сая төгрөг зарцуулагдаагүй, мөн 2020 онд Дархан арьс ширний цогцолборын төслийн бүтээн байгуулалтын ажил хийгдээгүйгээс олгохоор төлөвлөсөн 5,000.0 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийн зардал гараагүй;
- Хөрөнгийн зардлаас 13,185.2 сая төгрөгийг зарцуулаагүй нь Дархан арьс, ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах тендер зохион байгуулагдаагүй тул тус цогцолборын бүтээн байгуулалтын ажлын 10,000.0 сая төгрөгийн санхүүжилт гараагүй, мөн Ховд аймагт “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/” ажлын ТЭЗҮ, зураг, төсөв, төсөл боловсруулах, тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ хийж угсарч суурилуулах, барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж “Саруул цамхаг” ХХК шалгарсан боловч 2020 онд үүссэн цар тахлын үеийн нөхцөл байдлаас шалтгаалан улсын комисс хүлээн аваагүй, гүйцэтгэл хангагдаагүй тул 1,330.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоогүй байна.

Хөрөнгө оруулалтын 30 төсөл, арга хэмжээнд 33,770.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 20,585.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 42.6 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2,510.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 5,529.9 сая, Засгийн газрын нөөц сангаас 8,340.6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 7,458.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5,588.1 сая, нийт 26,917.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 24,041.2 сая, хөрөнгийн зардалд 2,956.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,153.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд шүүхээр шийдвэрлэгдсэн асуудлуудын талаарх судалгааг харьяа 11 байгууллагаас авсан бөгөөд нийт 80.7 тэрбум төгрөгийн 377 хэрэгт нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцон 32.5 тэрбум төгрөгийн 197 хэрэгт шүүхийн шийдвэр гарч, 48.1 тэрбум төгрөгийн 180 хэрэг шүүхийн шатанд явж байна. Мөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс шүүхэд ялагдал хүлээгээд байсан 12 ажилтанд холбогдох 31 удаагийн хэрэгт мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэн дүгнэлт гаргуулж, нэхэмжлэлийн шаардлагыг 17.4 сая төгрөгөөр бууруулан 4.4 сая төгрөгийн шаардлагыг хангаж, анхан шатны шүүхэд ялсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 38,234.7 сая, Хөдөө аж ахуйн бирж “МЭТУ” ХХК-тай холбоотой 425.9 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулахаар шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна.

Ховд аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт бүртгэлтэй, ХХААХҮЯ-аас “Баялаг буянт” ХХК-д 2009 онд олгосон 490.0 сая төгрөгийн ногоо даршлах төслийн зээлийн авлагыг барагдуулахаар 2018 онд шүүхийн шийдвэр гарсан боловч одоо хүртэл төлөлт хийгдээгүй байна.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны баримтаар нотлогдоогүй бараа материалын 1.3 сая, жолоочийн замын хуудсаар баталгаажуулаагүй 3.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нийт 4.6 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлүүлэхээр хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар ХААДС-ийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, зарим дансны үлдэгдэл болон ажил гүйлгээ нь хангалттай зохистой баримтаар нотлогдоогүй тул АДБОУС-ын дагуу дүгнэлт өгөхөөс татгалзсан, бусад харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 242,855.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Аудитаар илэрсэн зөрчлийг ангилан авч үзвэл:

- Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, тодорхойгүй, найдваргүй авлага, өглөг үүсгэсэн зэрэг зөрчил 228,628.4 сая төгрөг буюу нийт зөрчлийн 94.1 хувь;
- Хөрөнгийн ашиглалт, хадгалалтын горим зөрчигдсөн, эзэмшлийг шилжүүлэн аваагүй зөрчил 5,570.7 сая төгрөг буюу 2.3 хувь;

- Төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зөрчил 3,620.3 сая төгрөг буюу 1.5 хувь;
- Холбогдох стандарт, хууль, дүрэм журмын нийцлийг хангаагүй зөрчил буюу 3,229.3 сая төгрөг буюу 1.3 хувь;
- Дотоод хяналт, худалдан авах ажиллагааны хууль, дүрэм, журмын нийцэл хангаагүй зэрэг зөрчил 1,807.0 сая төгрөг буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь 2020 онд нийт 17 үндсэн чиг үүргийн хүрээнд 67 зорилт дэвшүүлж, 285 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 204 арга хэмжээг бүрэн, 40 арга хэмжээг 70 хувьтай, 8 арга хэмжээг 30 хувьтай хэрэгжүүлж, 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж тайлагнасан байна.

### **3.9 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд 139 мэдээлэл байршуулахаас 112 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг тэмдэглэж мэдээлээгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж хүргүүлснээс “Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, авлага өр, төлбөрийг бууруулах, бүртгэл тайлагналыг сайжруулах, төсвийн ерөнхийлөн захирагч үр дүнг дүгнэн холбогдох арга хэмжээ авч ажиллах” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

### **3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд ажиглагдаа. Үүнд:

#### **Анхаарал татахуйц асуудал:**

Сангийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 8-2/5018 дугаар албан бичгээр “Сангийн удирдлагыг шилжүүлэх” тухай хэрэгжилтийг хангуулан ажиллах чиглэл өгсний дагуу Сангийн яамнаас Зээлийн батлан даалтын сан тус сайдын багцад шилжин ирсэн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан Засгийн газрын гишүүний чиг үүрэгтэй нийцэхгүй байгаад анхаарч, дараагийн аудитаар нарийвчлан авч үзнэ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар зүйлд “Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ” гэж заасны дагуу Сангийн сайд “Санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд “Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн бодлого”-ын асуудал эрхлэхээр хуульчилсан байна.

#### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

- Салбарын хэмжээнд үүссэн тодорхойгүй, насжилт ихтэй, найдваргүй болсон авлага, өр төлбөрийн үлдэгдэлд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэх.
- Хөдөө аж ахуйг дэмжих санд Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах санг нэгтгэсэн эхлэлийн балансыг үнэн зөв нэгтгэсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар дахин авч үзнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 60 санхүүгийн тайлан нэгтгэснээс, 54 нь аудитад хамрагдаж, 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар 46 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 6 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

##### 4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 262,428.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 19,572.3 сая төгрөгийн 92 алдааг аудитын явцад залруулж, 50.1 сая төгрөгийн зөрчилд 36 төлбөрийн акт тогтоож, 238,687.4 сая төгрөгийн зөрчилд 81 албан шаардлага хүргүүлж, 4,118.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 125 зөвлөмж өгчээ.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний зөрчилтэй илэрхийлэгдэж, хангалттай зохистой баримтаар нотлогдоогүй тул дүгнэлт өгөхөөс татгалзаж, Мал эмнэлгийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан, Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Ховд аймгийн Мал эмнэлгийн газар зэрэг 6 санхүүгийн тайлан материаллаг хэмжээний зөрчилтэй илэрхийлэгдсэн тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн тайланд санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаагаас хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нягтлан бодох бүртгэл алдаатай, бараа материалын дутагдал гарсан зэрэг зөрчил илэрсэн тул “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

##### 4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

##### Албан шаардлага

1. ХААДС-ийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, зарим дансны үлдэгдэл болон ажил гүйлгээ нь хангалттай, зохистой баримтаар нотлогдоогүй тул АДБОУС-ын дагуу дүгнэлт өгөхөөс татгалзсан, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил илэрсэн байна.

Энэ нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тооцсон материаллаг байдлын түвшингээс давж, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “*өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах*”, 14.2.10-т “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 139 мэдээлэл байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 4.1.3-т “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1.6-д “*төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.



## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Харьяа төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 262,428.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 19,572.3 сая төгрөгийн 92 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 242,855.7 сая төгрөгийн зөрчилд 50.1 сая төгрөгийн 36 төлбөрийн акт тогтоож, 238,687.4 сая төгрөгийн 81 албан шаардлага хүргүүлж, 4,118.2 сая төгрөгийн 125 зөвлөмж өгчээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 27 дугаар зүйлийн 27.1.1-д “төсвийн зарчмыг мөрдлөг болгох 6 дугаар зүйлийн 6.6.1-д төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасантай нийцээгүй, “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Толилуулга ба Тодруулга” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Аудитаар илэрсэн илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг авах;

### **2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнахдаа Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бараа материалын дансны үлдэгдлийг төсөвт байгууллагуудад мөрдөгдөх дансны ангиллаар, зарим бараа материалын үлдэгдлийг дансны ангилал зөрүүлэн бүртгэсэн байна. Мөн бусад биет бус хөрөнгийн дансанд программ хангамжийг бүртгэн, үндсэн хөрөнгийг дансны ангилал буруу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” гэж заасантай болон, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-тай тус тус нийцэхгүй, “Толилуулга ба тодруулга”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **2.3 Өгсөн зөвлөмж:**

Бараа материал, үндсэн хөрөнгийг холбогдох стандарт, батлагдсан дансны ангиллын дагуу үнэн зөв ангилан бүртгэж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр						Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс:		
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт														Тоо	Дүн	Тоо
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан													
А		1	2	3	4	5	6	7	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
<b>I. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН</b>																					
1	1	ХХААХҮС-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан			1				4	-					2		2				
<b>ДҮН</b>			-	-	-	1	-	-	4	-	-	-	-	-	2	-	2	-	-	-	
<b>II. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН</b>																					
2	1	Мал эмнэлгийн ерөнхий газар			1				9	1,590.0	2	275.0			2	0.9	5	1,314.1			
2	1	Харьяа байгууллагууд		1	21	2	1		148	5,748.2	41	4,343.9	18	23.2	34	753.5	55	627.6	1	4.6	
<b>ДҮН</b>			-	1	21	3	1	-	157	7,338.2	43	4,619	18	23	36	754	60	1,942	1	5	
<b>I.ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>																					

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	1	Биокомбинат УТҮГ			1			20	1,698.9	7	446.6	1	0.6	2	1,091.4	10	160.3				
4	2	Хөдөө аж ахуйн бирж ХХК			1			6	17.5	3	17.5			1		2					
5	3	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци			1			4	2.2	1	2.2					3					
6	4	Зээлийн батлан даалтын сан				1		8	5,296.4			1	2.9	5	3,763.9	2	1,529.6				
<b>ДҮН</b>					<b>3</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>38</b>	<b>7,015.0</b>	<b>11</b>	<b>466.3</b>	<b>2</b>	<b>3.5</b>	<b>8</b>	<b>4,855.3</b>	<b>17</b>	<b>1,689.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>IV. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>																					
7	1	Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			3	2.7					2	2.7	1					
8	2	Баян-Өлгий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1					-	-												
9	3	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			8	17.5	2	14.6	1	0.2			5	2.7				
10	4	Булган аймгийн Хүнс, хөдөө аж			1			6	7.0	2	0.7					4	6.3				

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		ахуйн газар																		
11	5	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			10	42.1	1	4.9	4	1.4	4	34.7	1	1.1			
12	6	Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			5	7.6	2	5.7	2	1.9			1				
13	7	Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			5	44.8	1	3.3					4	41.5			
14	8	Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			1	-							1				
15	9	Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			3	11.9			1	2.0	2	9.9					
16	10	Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1					-	-											
17	11	Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			1	-						-	1				
18	12	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1			4	6.8					2	6.5	2	0.3			

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

19	13	Өвөрхангай Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				-	-									
20	14	Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				4	1,459.3	2	1,457.6				2	1.7		
21	15	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				9	26.2	1	18.8	4	1.7	3	5.7	1		
22	16	Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1						-	-									
23	17	Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				8	1,038.0	4	1,014.7			1	21.8	3	1.5	
24	18	Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1						-	-									
25	19	Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				6	790.0	1	0.1	1	4.6	2	733.2	2	52.1	
26	20	Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				3	40.4					1	6.4	2	34.0	
27	21	Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар			1				7	249.6	3	7.2			2	5.4	2	237.0	

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

28	22	Малын удмын сангийн үндэсний төв			1			9	649.2	4	608.8	2	10.9	1	6.7	2	22.8				
29	23	Аймаг дундын Отрын бэлчээр ашиглалтын захиргаа			1			6	48.7	1	45.5	1	0.7			4	2.5				
30	24	Халх гол бүтээн байгуулалтын бүс			1			3	22.1	1	17.9			1		1	4.2				
31	25	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв			1			1	4.5		4.5										
32	26	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв			1			5	24.5	3	24.2					2	0.3				
33	27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам			1			11	157.8	3	33.6			2	42.5	6	81.7				
34	28	Жижиг дунд үйлдвэрийн газар		1				-	-												
<b>ДҮН</b>			<b>4</b>	<b>1</b>	<b>22</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>117</b>	<b>4,650.7</b>	<b>31</b>	<b>3,262.1</b>	<b>16</b>	<b>23.4</b>	<b>24</b>	<b>875.5</b>	<b>47</b>	<b>489.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>V.ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>																					

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35	1	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан				1		12	169,842.9	7	11,225.0			4	158,617.9	1				
36	2	Хөдөө аж ахуйг дэмжих сан					1	10	73,584.3					10	73,584.3					
<b>ДҮН</b>			-	-	-	1	-	1	22	243,427.2	7	11,225.0	-	-	14	232,202.2	1	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>			4	2	46	7	1	1	338	262,428.0	92	19,572.3	36	50.1	83	238,687.4	127	4,118.2	1	4.6

**6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт**

**7.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тавигдсан төлбөрийн актын нэгтгэл**

Д/д	№	Байгууллагын нэр	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
<b>I. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>						
1	1	Биокомбинат УТҮГ	Томилолтоор ажиллах байх хугацаан дахь хоолны мөнгийг давхардуулан олгосон.	0.6	Дарга, Нягтлан бодогч	Б.Цолмон Б.Оюуцэцэг
2	2	Зээлийн батлан даалтын сан	Тайлант онд нэр бүхий 2 ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, нийт 2.9 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.	2.9	Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч	Ш.Алтанчимэг Б.Батбаяр
<b>ДҮН</b>				<b>3.5</b>		
<b>II. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ</b>						
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд</b>						
3	1	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори	Өмнөх жилийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй	0.7	Дарга Нягтлан бодогч	Б.Ганзориг Б.Золзаяа
4	2	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	Хувийн мал эмнэлэгт олгосон санхүүжилтийг тулгахад Баянлиг сумын "Баянлиг буянт сүрэг" ХХК-д 1.0 төгрөгийн санхүүжилтийг илүү, Богд сумын "Богд Эрдэнэ оргил" ХХК-д 1.0 төгрөгийг дутуу олгосон байхад санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй.	1.0	Дарга Нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ С.Цэнд-Аюуш
5	3	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	Тайлант оны эцэст шатахууны хэмнэлтийг төвлөрүүлэлгүй, тайлант онд зарцуулсан шатахууны гүйцэтгэлтэй харьцуулахад оны эцэст 2.6 сая төгрөгийн шатахууныг хэрэгцээнээс илүү нөөцөлсөн, 0.2 сая төгрөгийн материалыг анхан шатны баримтгүй зарлагдсан.	2.6	Дарга Нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ С.Цэнд-Аюуш
6	4	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	Түүврийн аргыг ашиглан зарим бараа материалын зарлагыг шаардах хуудастай тулган шалгахад нийт 0.2 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүй зарлагдсан.	0.2	Дарга Нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ С.Цэнд-Аюуш
7	5	Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	Албан томилолтоор ажилласан ажилчдад 1.0 төгрөгийн томилолтыг илүү тооцон олгосон байна.	1.0	Дарга Нягтлан бодогч	Б.Наянбуу Д.Болормаа
8	6	Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	Сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.2 сая мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	0.2	Дарга Нягтлан бодогч	Б.Наянбуу Д.Болормаа



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	7	Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар	Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулаагүй, байгууллагын төсвөөс олгосон.	2.6	Дарга Нягтлан бодогч	Ч.Отгонсүрэн Т.Оюунчимэг
10	8	Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар	Тээвэр шатахууны зардлын хэмнэлтийг хэрэглээнээс илүү нөөц бэлтгэж төсөвт буцаан төвлөрүүлээгүй.	1.5	Дарга Нягтлан бодогч	Ч.Отгонсүрэн Т.Оюунчимэг
11	9	Завхан аймгийн Мал эмнэлгийн газар	Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	1.7	Дарга Нягтлан бодогч	Д.Баясгалан Н.Ариунсайхан
12	10	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар	Шатахууны урамшууллын орлого 0.2 сая төгрөгийг орлогод бүртгэлгүй шууд зарцуулсан	0.2	Дарга Нягтлан бодогч	П.Эрдэнэжаргал Э.Нямдорж
13	11	Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газар	Жолоочийн тооцоог Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормтой тулгахад 142.1 литер буюу 0.2 сая төгрөгийн шатахуун илүү олгосон байна.	0.2	Дарга Нягтлан бодогч	П.Одбаяр Ц.Отгончулуун
14	12	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 0.1 сая төгрөгөөр илүү олгож, төсвийг илүү зарцуулсан, 1.2 сая төгрөгийг бодож олгоогүй байна.	1.3	Дарга Нягтлан бодогч	М.Молорчимэг Э.Угтахбаяр
15	13	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	Ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон, төсвийг илүү зарцуулсан.	0.2	Дарга Нягтлан бодогч	М.Молорчимэг Э.Угтахбаяр
16	14	Төв аймгийн Мал эмнэлгийн газар	Албан томилолт болон цалинг илүү бодож олгосон	0.5	Дарга Нягтлан бодогч	Б.Болдбаатар Б.Санчир
17	15	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	Хүн амын орлогын албан татварын 0.2 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн.	0.2	Дарга Нягтлан бодогч	Д.Батцэнгэл Л.Энхтуул
18	16	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	Тушаалаар суутгах сахилгын шийтгэлийг 0.8 сая төгрөгөөр дутуу суутгасан.	0.8	Дарга Нягтлан бодогч	Д.Батцэнгэл Л.Энхтуул
19	17	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	Өглөгт тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, төсвийн зориулалт бус зардал гаргасан нийт 3.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	3.5	Дарга Нягтлан бодогч	Д.Батцэнгэл Л.Энхтуул
20	18	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	Цалингийн нэмэгдлийг 4.8 сая төгрөг буруу тооцож олгосон.	4.8	Дарга Нягтлан бодогч	Д.Батцэнгэл Л.Энхтуул
<b>Дүн</b>				<b>23.2</b>		
<b>III. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>						
21	1	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Өмнөх онд Төрийн аудитын газраас тогтоосон 220,8 мянган төгрөгийн төлбөрийн актыг холбогдох буруутай хүмүүсээр төлүүлээгүй төсвийн мөнгөнөөс шилжүүлж барагдуулсан байна.	0.2	Дарга, Нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
22	2	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Шатахууны зарцуулалтыг тооцоход 0.1 төгрөгийн шатахууныг нотлох баримтгүйгээр зарцуулсан.	0.1	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Л.Насанбуян, Т.Галсан

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

23	3	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Албан томилолтоор ажилласан ажиллагсад 0.4 сая төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон байна.	0.4	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Л.Насанбуян, Т.Галсан
24	4	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Ээлжийн амралтын тооцоог хийхэд 1 ажилтанд 0.6 сая төгрөгийн цалинг дутуу олгосон.	0.6	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Л.Насанбуян, Т.Галсан
25	5	Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Хувь хүний нэрийн данс руу бэлнээр шилжүүлсэн 3.0 сая төгрөгөөс суутган тооцсон хувь хүний орлогын албан татварыг шилжүүлээгүй.	0.3	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Л.Насанбуян, Т.Галсан
26	6	Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Тээвэр шатахууны зардлын хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлэлгүй, хэрэглээнээс илүү нөөц бэлтгэсэн, төсвийг хэмнэлттэй, зөв зохистой удирдан зохион байгуулаагүй	1.3	Дарга, Нягтлан бодогч	Н.Даваахүү, Б.Мэндбаяр
27	7	Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг 2 ажилтанд олгохдоо журмыг зөрчиж урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн илүү тооцож зориулалтын бус зардлаас олгосон	0.6	Дарга, Нягтлан бодогч	Н.Даваахүү, Б.Мэндбаяр
28	8	Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулалгүйгээр 5.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан.	2.0	Дарга, Нягтлан бодогч	Ж.Алимаа, Б.Золзаяа
29	9	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 0.3 сая төгрөгөөр илүү, 0.1 сая төгрөгөөр дутуу бодсон.	0.3	Дарга, Нягтлан бодогч	Т.Ган-Очир Б.Мөнхзул
30	10	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Цмалингийн урьдчилгааг суутгаагүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн.	0.1	Дарга, Нягтлан бодогч	Т.Ган-Очир Б.Мөнхзул
31	11	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал 0.7 сая төгрөгийг олгож, төсвийг үргүй зарцуулсан.	0.7	Дарга, Нягтлан бодогч	Т.Ган-Очир Б.Мөнхзул
32	12	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Шатахууны нормативт зардлыг хэтрүүлэн, зарцуулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан.	0.6	Дарга, Нягтлан бодогч	Т.Ган-Очир Б.Мөнхзул

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

33	13	Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Шатахууны тооцоо бодоогүй, Ник ХХК-д шилжүүлсэн дүн, шатах тослох материалын тайлангийн орлого, зарлага зөрүүтэй, орлого, зарлагын баримтаар баталгаажуулаагүй, албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, ажилчдадаа зах зээлийн үнээс хямд үнээр мал олгоод үнийг нь суутган аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, газрын даргын 2020 оны 02-р сарын 20-ны А/9 тоот тушаалаар ахмад настнуудад гарын бэлэг дурсгалын зүйл олгохдоо ашгийн татвар суутган тооцоод татварт шилжүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.	4.6	Дарга, Нягтлан бодогч	Б.Бямбажав Д.Батбаатар
34	14	Малын удмын сангийн үндэсний төв	Албан тушаалын автомашин хэрэглэсэн албан тушаалтанд 1.0 сая төгрөгийн унааны мөнгө давхардуулан олгосон.	1.0	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.
